

Төрийн албаны зөвлөлийн
2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн
217 дугаар тогтоолын 16 дугаар хавсралт

АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:

2025.05.21

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Эрүүл мэндийн яам

Санхүү, эдийн засгийн бодлогын газар

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл

Эрүүл мэндийн салбарын төсөв, санхүүгийн
нэгдсэн мэдээ, үйл ажиллагааны
төлөвлөгөө, тайлангийн нэгтгэл хариуцсан
шинжээч

Ахлах түшмэл, ТЗ-5

Ажлын цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

Ажлын өдөр 8 цаг

Улаанбаатар 14210, Сүхбаатар дүүрэг,
Олимпын гудамж 2, Засгийн газрын 8
дугаар байр

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Эрүүл мэндийн салбар дахь санхүү, эдийн засгийн нэгдсэн удирдлагыг хэрэгжүүлэхэд
салбарын төсөв, санхүүгийн нэгдсэн мэдээ, үйл ажиллагааны төлөвлөлт, тайлангийн
нэгтгэлийг хэлтсийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, тэтгэмж, урамшууллын бодлого, хэрэгжилтийн нэгдсэн зохион байгуулалт, тооцоо, судалгааны нэгтгэл хийх, тайлагнах;
2. Эрүүл мэндийн байгуулллагад үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний бодлого, хэрэгжилтийн зохицуулалт, холбогдох тооцоолол, судалгаа, дүн шинжилгээ хийх;
3. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон холбогдох бусад төлөвлөгөөнд туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг тайлагнах;
4. Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, байгууллагын болон нэгжийн дотоод ажилд оролцох, удирдлагаас хууль ёсны хүрээнд өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Гүйцэтгэх-Г Хянах - Х Шийдвэрлэх - Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1. Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, тэтгэмж, урамшууллын бодлого, хэрэгжилтийг зохион байгуулах	Бодлогын хэрэгжилт, зохицуулалт хийгдсэн байна.	Г, Х
	2. Эрүүл мэндийн салбарын цалин хөлс, тэтгэмж, урамшуулалтай холбоотой мэдээ мэдээлэл цуглуулах, холбогдох тооцоо, судалгаа хийж, нэгтгэн дүгнэх	Холбогдох тооцоо, судалгаа хийгдэж, нэгтгэгдсэн байна.	Г, Х
	3. Эрүүл мэндийн тухай хуулийн дагуу эрүүл мэндийн ажилтанд олгох мөнгөн тэтгэмжийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, нэгтгэх, тайлагнах	Хуулийн хэрэгжилт хангагдаж, тэтгэмж олгогдсон байна.	Г, Х
2 дугаар зорилтын хүрээнд	1. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний жишиг хэмжээ, тооцоолол, судалгаа хийх	Холбогдох тооцоо, судалгаа хийгдэж, нэгтгэгдсэн байна.	Г, Х
	2. Төлбөртэй тусламж, үйлчилгээний хэрэгжилт, зохицуулалтад холбогдох дүн шинжилгээ хийх	Дүн шинжилгээ хийгдсэн байна.	Г, Х
	3. Эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх төлбөртэй тусламж, үйлчилгээний чиглэлээр баримтлах бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийх, боловсруулах	Холбогдох тушаал шийдвэрийг өөрчлөх, шинэчлэх талаар дүгнэлт гарч хийгдсэн байна.	Г, Х

3 дугаар зорилтын хүрээнд	1. “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг нэгтгэх, тайлагнах	Эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээний тайлан нэгтгэгдэж гарсан байна.	Г, Х
	2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг нэгтгэх, тайлагнах	Эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээний тайлан нэгтгэгдэж гарсан байна.	Г, Х
	3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг тайлагнах	Эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх тайлан нэгтгэгдэж гарсан байна.	Г, Х
	4. Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон холбогдох бусад хууль тогтоомжинд туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг тайлагнах	Эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээний тайлан нэгтгэгдэж гарсан байна.	Г, Х
	5. Эрүүл мэндийн яамны үйл ажиллагааны төлөвлөгөөнд туссан эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээг тайлагнах үйл ажиллагаа	Эрүүл мэндийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээрх зорилт, арга хэмжээний тайлан нэгтгэгдэж гарсан байна.	Г, Х
4 дүгээр зорилтын хүрээнд	1. Шилэн данс болон бусад холбогдох хуулийг хэрэгжүүлэх, тайлагнах	Хуулийн хэрэгжилт хангагдсан байна.	Г, Х
	2. Хариуцсан асуудлаарх салбар дундын хамтын ажиллагааг хангах	Салбар дундын хамтын ажиллагаа хангагдсан байна	Г, Х
	3. Хариуцсан асуудлаарх тайлагналт, албан бичиг, өргөдөл гомдлын шийдвэрлэлт, мэдээллээр хангах	Албан бичиг, өргөдөл гомдол шийдвэрлэгдсэн байна.	Г, Х
	4. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивын нэгж бүрдүүлж, хүлээлгэн өгөх	Холбогдох баримтыг архивт хүлээлгэн өгсөн байна.	Г, Х

	5.Хариуцсан асуудлын хүрээнд яамны болон төрийн жинхэнэ албан хаагчийн тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, тайлагнах	Нэгжийн болон албан хаагчийн тайлан, мэдээг хугацаанд нь үнэн зөв гарсан байна.	Г, Х
III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА			
Боловсрол	Магистр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй.		
Мэргэжил	- эдийн засаг /0311/; - менежмент ба удирдахуй /0413/;		
Мэргэшил	Төрийн албан хаагчийн дунд хугацааны сургалтад хамрагдаж, төгссөн байх		
Туршлага	Төрийн албанд 6 жил, үүнээс дэс түшмэлийн албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан байх. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн бол төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан байх.		
	Дүн шинжилгээ хийх	- тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн талаарх мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах, харьцуулан судлах; - тогтоол, шийдвэрийн хэрэгжилт дэх нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх; - нэгжийн дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэрийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж, шийдлийн хувилбарыг зөвлөх; - бусад.	
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх; - албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хуульд нийцсэн, оновчтой шийдвэрийг шуурхай гаргах; - асуудлыг хууль тогтоомж, ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - гаргасан шийдвэрийнхээ талаар хариуцлага хүлээх; - бусад.	
	Багаар ажиллах	- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах, үлгэрлэн манлайлах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч харилцаа бий болгох; - ажил хэрэгч, бүтээлч, санаачлагатай ажиллах; - хувийн зохион байгуулалт, ажлын цаг ашиглалтын хувьд бусдыг манлайлах; - бусад.	

	Бусад	- төрийн албан хаагчийн ёс зүй, байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ажлын цагийг баримтлан ажиллах; - ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх; - хүний эрхийн мэдрэмжтэй байх; - жендерийн эрх тэгш байдлын зарчмыг баримтлах; - албан ажлын чиг үүргийн дагуу хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө мэдээллээр ханган ажиллах чадвартай байх; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - архив, албан хэрэг хөтлөлт, албан бичгийн боловсруулалт, монгол хэл, найруулгын чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах чадвартай байх; - англи хэл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах чадвартай байх; - хариуцлага хүлээх, алдаагаа ухамсарлах, засах, дүгнэлт хийх чадвартай байх; - албан ажлын хүрээнд олж авсан төр, байгууллага, хувь хүний мэдээллийг нууцлах; - бусад.
--	-------	---

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Санхүү, эдийн засгийн бодлогын газрын Санхүү, даатгалын хэлтсийн дарга

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Холбогдох чиглэлээр төрийн бусад байгууллага, яам, агентлаг тэдгээрийн газар, хэлтэс, нэгжийн холбогдох албан хаагч;
- Мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан, иргэн;
- Эрүүл мэндийн яамны харьяа агентлаг, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын албан хаагч.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

Байгууллагын нэр:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГА..... /Б.БАТБАЯР/

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн
огноо: 25 05 21

Дугаар: 217

2025 оны ... сарын ... -ны өдөр

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМ

Шийдвэрийн огноо:.....

Дугаар:.....

(тамга/тэмдэг)

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА/Д.ОЧИРБАТ/

2025 оны ... дугаар сарын ... -ны өдөр

